



## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Рашаант сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: БУА-2026/22/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Булган аймаг 2026 он	Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: П.Мөнхтуяа Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



### БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.02.16 № 81  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

РАШААНТ СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
М.БОЛДСАЙХАН ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Рашаант сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Рашаант сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Рашаант сумын Засаг даргын тамгын газар нь 2025 онд орон нутгийн төсвөөс 1,097 мянга, нэмэлт дансаар 89.6 сая төгрөг буюу нийт 1,186.6 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 1,186.4 мянган төгрөгийг зарцуулж 0.2 сая төгрөгийн үлдэгдлийг төсөвт төвлөрүүлсэн байна.

#### Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Рашаант сумын Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/49 тоот “Хөрөнгө шилжүүлэх, дахин үнэлэх, данснаас хасаж актлах тухай” тушаалыг үндэслэн дахин үнэлгээгээр барилга байгууламжийг 79.5, машин тоног төхөөрөмжийг 14.5, тавилга эд хогшлыг 8.4,

бусад үндсэн хөрөнгийг 79.8 сая төгрөгөөр тус тус дахин үнэлж, аймгийн Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/686 тоот “Хөрөнгө бүртгэлд авах тухай” захирамжийг үндэслэн улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн 163.3 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг орлогод авч үндсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 7 зорилтын хүрээнд 16 ажил төлөвлөснөөс гүйцэтгэлээр 15 ажил бүрэн хийгдэж, 1 ажил нь 70 хувьтай хэрэгжиж, 92 хувиар үнэлэгджээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Тодруулга	/мянган төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>79,800.70</b>	<b>69,022.16</b>
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>6</b>	<b>79,800.70</b>	<b>69,022.16</b>
Хангамжийн материал		79,800.70	69,022.16
Бичиг хэргийн материал		629.60	719.60
Аж ахуйн материал		79,171.10	67,611.86
Түлш, шатах тослох материал		-	690.70
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>3,393,202.94</b>	<b>3,440,726.91</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>7</b>	<b>3,393,202.94</b>	<b>3,440,726.91</b>
Биет хөрөнгө		3,356,230.04	3,404,016.51
Барилга, байгууламж, орон сууц		1,655,326.71	1,734,896.71
Хуримтлагдсан элэгдэл		(483,733.88)	(572,175.81)
Авто-тээврийн хэрэгсэл		334,526.33	414,426.33
Хуримтлагдсан элэгдэл		(82,000.92)	(134,034.45)
Машин тоног төхөөрөмж(компьютер)		270,373.82	419,675.61
Хуримтлагдсан элэгдэл		(109,979.04)	(128,209.31)
Тавилга, аж ахуйн эд хогшил		32,459.53	37,912.66
Хуримтлагдсан элэгдэл		(3,313.66)	(5,522.19)
Бусад үндсэн хөрөнгө		1,929,127.59	1,982,555.65
Хуримтлагдсан элэгдэл		(186,556.44)	(345,508.69)
Биет бус хөрөнгө		36,972.90	36,710.40
Програм хангамж		2,850.00	2,850.00
Хуримтлагдсан элэгдэл		(2,587.50)	(2,850.00)
Бусад биет бус хөрөнгө		36,710.40	36,710.40
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>		<b>3,473,003.65</b>	<b>3,509,749.07</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		-	<b>2,888.64</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		-	<b>2,888.64</b>

Өглөг	9	-	2,888.64
Бусад өглөг		-	2,888.64
Байгууллагад төлөх өглөг		-	2,888.64
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>3,473,003.65</b>	<b>3,506,860.43</b>
Засгийн газрын хувь оролцоо		3,473,003.65	3,506,860.43
Засгийн газрын оруулсан капитал		467,648.00	467,648.00
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		467,648.00	467,648.00
Хуримтлагдсан үр дүн		2,131,186.55	2,165,043.33
Өмнөх үеийн үр дүн		913,013.01	2,131,186.55
Тайлант үеийн үр дүн		1,218,173.54	33,856.78
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		874,169.11	874,169.11
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>3,473,003.65</b>	<b>3,509,749.07</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Тодруулга	/мянган төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2</b>	<b>2,735,793.38</b>	<b>1,552,214.36</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>1,386,458.73</b>	<b>1,552,214.36</b>
Нийтлэг татварын бус орлого		1,386,458.73	365,633.47
Төсөв байгууллагын өөрийн орлого		1,386,458.73	-
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		1,386,458.73	-
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		-	365,633.47
Тусламжийн орлого		-	1,186,580.89
Тусламжийн орлогоХандив тусламж /дотоод/		-	1,186,580.89
Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого		-	1,097,016.80
Урсгал санхүүжилтийн орлого\		-	1,097,016.80
Нэмэлт санхүүжилтийн орлого		-	89,564.09

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		-	86,279.09
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		-	3,285.00
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>1,349,334.65</b>	<b>-</b>
Нэмэлт санхүүжилтийн орлого		129,848.75	-
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		23,312.00	-
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		106,011.75	-
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		525.00	-
Орон нутгийн төсвөөс санхүүжих		1,219,485.90	-
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		1,219,485.90	-
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3</b>	<b>1,517,619.84</b>	<b>1,486,078.34</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>1,517,619.84</b>	<b>1,486,078.34</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>1,456,658.36</b>	<b>1,483,480.15</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		665,682.30	748,121.21
Үндсэн цалин		369,661.00	397,250.14
Нэмэгдэл		258,521.30	302,535.10
Урамшуулал		37,500.00	48,335.97
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		83,400.80	97,841.79
Тэтгэврийн даатгалын зардал		56,712.40	63,625.09
Тэтгэмжийн даатгалын зардал		6,672.10	7,476.60
ҮОМШӨ-ний даатгалын зардал		3,336.10	8,062.32
Ажилгүйдлийн даатгалын зардал		3,336.10	3,738.40
Эрүүл мэндийн даатгалын зардал		13,344.10	14,939.38
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		124,480.16	131,032.04
Гэрэл, цахилгаан		28,877.10	48,878.64

Түлш, халаалт		95,093.26	81,553.50
Цэвэр, бохир ус		509.80	599.90
Хангамж, бараа материалын зардал		44,639.65	30,655.15
Бичиг хэрэг		3,760.00	2,530.25
Тээвэр, шатахуун		30,312.00	18,034.20
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		2,477.55	2,159.70
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		6,199.90	7,006.50
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,890.20	924.50
Нормативт зардал		900.00	922.30
Нормын хувцас, зөөлөн эдлэл		900.00	922.30
Эд хогшил, урсгал засварын зардал		25,190.40	27,696.42
Багаж, техник, хэрэгсэл		-	5,096.00
Урсгал засвар		25,190.40	22,600.42
Томиллолт, зочны зардал		15,929.00	7,420.00
Гадаад албан томилолт		6,556.00	-
Дотоод албан томилолт		9,373.00	7,420.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4,014.63	986.60
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,191.16	-
Даатгалын үйлчилгээ		374.38	374.40
Тээврийн хэрэгслийн татвар		361.10	74.20
Тээврийн хэрэгслийн оношлогоо		88.00	88.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ		-	450.00
Бараа үйлчилгээний бусад зардал		492,421.42	438,804.64
Бараа үйлчилгээний бусад зардал		313,019.73	53,967.13
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		2,930.00	1,628.00

Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		176,471.69	383,209.51
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>60,961.49</b>	<b>2,598.19</b>
Засгийн газрын урсгал шилжүүлэг		-	198.19
Засгийн газрын дотоод шилжүүлэг		-	198.19
Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		-	198.19
Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\		-	8.19
Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\		-	190.00
Бусад урсгал шилжүүлэг		56,021.50	2,400.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		25,740.00	-
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		27,281.50	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		3,000.00	2,400.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		4,939.99	-
Төвлөрүүлэх шилжүүлэг		4,414.99	-
Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		525.00	-
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		<b>1,218,173.54</b>	<b>66,136.02</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>-</b>	<b>32,279.24</b>
Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз		-	32,279.24
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)</b>		<b>-</b>	<b>(32,279.24)</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>		<b>1,218,173.54</b>	<b>33,856.78</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	/мянган төгрөгөөр/	
	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>ДҮН</b>	<b>1,349,334.65</b>	<b>1,186,580.89</b>
<b>ОРЛОГО</b>	<b>-</b>	<b>1,186,580.89</b>
Нийтлэг татварын бус орлого	-	23,059.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	-	23,059.00

Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	-	23,059.00
Тусламжийн орлого	-	1,163,521.89
Хандив тусламж /дотоод/	-	1,163,521.89
<b>Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого</b>	-	<b>1,073,957.80</b>
<b>Урсгал санхүүжилтийн орлого</b>	-	<b>1,073,957.80</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>89,564.09</b>
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	86,279.09
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,285.00
<b>ОРЛОГО</b>	<b>1,349,334.65</b>	<b>-</b>
Нэмэлт санхүүжилтийн орлого	129,848.75	-
ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,312.00	-
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	106,011.75	-
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	525.00	-
Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,219,485.90	-
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,219,485.90	-
<b>ДҮН</b>	<b>1,297,834.65</b>	<b>1,101,480.89</b>
<b>ЗАРДАЛ</b>	<b>1,297,834.65</b>	<b>1,101,480.89</b>
<b>ЗАРДАЛ</b>	<b>1,236,873.16</b>	<b>1,098,882.70</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>665,682.30</b>	<b>748,121.21</b>
Үндсэн цалин	369,661.00	397,250.14
Нэмэгдэл	258,521.30	302,535.10
Урамшуулал	37,500.00	48,335.97
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>83,400.80</b>	<b>97,841.79</b>
Тэтгэврийн даатгалын зардал	56,712.40	63,625.09
Тэтгэмжийн даатгалын зардал	6,672.10	7,476.60
ҮОМШӨ-ний даатгалын зардал	3,336.10	8,062.32
Ажилгүйдлийн даатгалын зардал	3,336.10	3,738.40
Эрүүл мэндийн даатгалын зардал	13,344.10	14,939.38
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>124,570.36</b>	<b>130,153.40</b>

Гэрэл, цахилгаан	28,877.10	48,000.00
Түлш, халаалт	95,093.26	81,553.50
Цэвэр, бохир ус	600.00	599.90
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>53,549.45</b>	<b>31,615.05</b>
Бичиг хэрэг	3,760.00	2,620.25
Тээвэр, шатахуун	39,312.00	18,904.10
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,477.55	2,159.70
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,199.90	7,006.50
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800.00	924.50
<b>Нормативт зардал</b>	<b>900.00</b>	<b>1,642.30</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	900.00	1,642.30
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>24,532.90</b>	<b>27,696.42</b>
Багаж, техник, хэрэгсэл	-	5,096.00
Урсгал засвар	24,532.90	22,600.42
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>15,929.00</b>	<b>5,410.00</b>
Гадаад албан томилолт	6,556.00	-
Дотоод албан томилолт	9,373.00	5,410.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,014.63</b>	<b>986.60</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,191.16	-
Даатгалын үйлчилгээ	374.38	374.40
Тээврийн хэрэгслийн татвар	361.10	74.20
Тээврийн хэрэгслийн оношлогоо	88.00	88.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	450.00
Бараа үйлчилгээний бусад зардал	264,293.73	55,415.93
Бараа үйлчилгээний бусад зардал	261,363.73	53,787.93
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,930.00	1,628.00
<b>ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>60,961.49</b>	<b>2,598.19</b>
Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	198.19
Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	198.19
Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	198.19
Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	8.19
Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\	-	190.00

Бусад урсгал шилжүүлэг	56,021.50	2,400.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,740.00	-
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	27,281.50	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000.00	2,400.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,939.99	-
Төвлөрүүлэх шилжүүлэг	4,414.99	-
Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	525.00	-
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)</b>	<b>51,500.00</b>	<b>85,100.00</b>
ДҮН	51,500.00	85,100.00
ЗАРДАЛ	51,500.00	85,100.00
Дотоод эх үүсвэрээр	51,500.00	85,100.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	51,500.00	85,100.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (V)</b>	<b>(51,500.00)</b>	<b>(85,100.00)</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)</b>	<b>-</b>	<b>-</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Хамаарахгүй	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	/мянган төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	467,648.00	884,776.78	908,506.94	2,260,931.71
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	4,506.07	4,506.07
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	467,648.00	884,776.78	913,013.01	2,265,437.78
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(10,607.67)	-	(10,607.67)
Тайлант үеийн үр дүн	-	-	1,218,173.54	1,218,173.54
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	467,648.00	874,169.11	2,131,186.55	3,473,003.65
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	467,648.00	874,169.11	2,131,186.55	3,473,003.65

Дахин илэрхийлсэн үлдэгдэл	467,648.00	874,169.11	2,131,186.55	3,473,003.65
Тайлант үеийн үр дүн	-	-	33,856.78	33,856.78
2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	467,648.00	874,169.11	2,165,043.33	3,506,860.43

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>1,081,664.80</b>	<b>1,073,949.61</b>	<b>7,715.19</b>	99
Татварын бус орлого	1,081,664.80	1,073,949.61	7,715.19	99
Тусламжийн орлого	1,081,664.80	1,073,949.61	7,715.19	99
Төсвөөс санхүүжих	1,081,664.80	1,073,949.61	7,715.19	99
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,104,723.80</b>	<b>1,097,008.61</b>	<b>7,715.19</b>	99
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,104,723.80</b>	<b>1,097,008.61</b>	<b>7,715.19</b>	99
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,102,323.80</b>	<b>1,094,608.61</b>	<b>7,715.19</b>	99
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>747,663.70</b>	<b>747,435.21</b>	<b>228.49</b>	100
Үндсэн цалин	397,837.30	397,250.14	587.16	100
Нэмэгдэл	301,779.40	301,849.10	(69.70)	100
Урамшуулал	48,047.00	48,335.97	(288.97)	101
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>97,767.90</b>	<b>97,762.90</b>	<b>5.00</b>	100
Тэтгэврийн даатгал	63,551.20	63,546.20	5.00	100
Тэтгэмжийн даатгал	7,476.60	7,476.60	-	100
ҮОМШӨ-ний даатгал	8,048.40	8,062.32	(13.92)	100
Ажилгүйдлийн даатгал	3,738.40	3,738.40	0.00	100
Эрүүл мэндийн даатгал	14,953.30	14,939.38	13.92	100
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>130,153.50</b>	<b>130,153.40</b>	<b>0.10</b>	100

Гэрэл, цахилгаан	48,000.00	48,000.00	-	100
Түлш, халаалт	81,553.50	81,553.50	0.00	100
Цэвэр, бохир ус	600.00	599.90	0.10	100
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>32,950.00</b>	<b>29,360.85</b>	<b>3,589.15</b>	89
Бичиг хэрэг	3,500.00	2,620.25	879.75	75
Тээвэр, шатахуун	16,800.00	16,649.90	150.10	99
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,600.00	2,159.70	440.30	83
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,120.00	7,006.50	113.50	98
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,930.00	924.50	2,005.50	32
<b>Нормативт зардал</b>	<b>1,500.00</b>	<b>1,642.30</b>	<b>(142.30)</b>	109
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500.00	1,642.30	(142.30)	109
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>32,300.00</b>	<b>30,296.42</b>	<b>2,003.58</b>	94
Багаж, техник, хэрэгсэл	10,300.00	10,296.00	4.00	100
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000.00	-	2,000.00	-
Урсгал засвар	20,000.00	20,000.42	(0.42)	100
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,690.00</b>	<b>5,410.00</b>	<b>280.00</b>	95
Дотоод албан томилолт	5,690.00	5,410.00	280.00	95
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,473.50</b>	<b>986.60</b>	<b>486.90</b>	67
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	200.00	-	200.00	-
Даатгалын үйлчилгээ	374.40	374.40	-	100
Тээврийн хэрэгслийн татвар	361.10	74.20	286.90	21
Тээврийн хэрэгслийн оношлогоо	88.00	88.00	-	100
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450.00	450.00	-	100
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>52,825.20</b>	<b>51,560.93</b>	<b>1,264.27</b>	98
Бараа үйлчилгээний бусад зардал	51,125.20	49,932.93	1,192.27	98

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,700.00	1,628.00	72.00	96
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,400.00</b>	<b>2,400.00</b>	-	100
Бусад урсгал шилжүүлэг	2,400.00	2,400.00	-	100
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,400.00	2,400.00	-	100
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>(23,059.00)</b>	<b>(23,059.00)</b>	-	100
<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>23,059.00</b>	<b>23,059.00</b>	-	100
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	23,059.00	23,059.00	-	100
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>53</b>	<b>51</b>		<b>96</b>
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>		<b>100</b>
Төсвийн байгууллага	1	1		100
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>26</b>	<b>24</b>		<b>92</b>
Удирдах ажилтан	7	7		100
Гүйцэтгэх ажилтан	9	9		100
Үйлчлэх ажилтан	4	2		50
Гэрээт ажилтан	6	6		100
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>26</b>	<b>24</b>		<b>92</b>
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9		100
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11	9		82
Улс төрийн албан хаагч (УТ)	6	6		100

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	/мянган төгрөгөөр/
	Тайлант он
<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>89,564.09</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>89,564.09</b>
Тусламжийн орлого	89,564.09

Хандив тусламж /дотоод/	89,564.09
Нэмэлт санхүүжилтийн орлого	89,564.09
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	86,279.09
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,285.00
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>89,374.09</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>89,374.09</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>89,374.09</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	686.00
Нэмэгдэл	686.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78.89
Тэтгэврийн даатгал	78.89
Хангамж, бараа материалын зардал	2,254.20
Тээвэр, шатахуун	2,254.20
Эд хогшил, урсгал засварын зардал	82,500.00
Багаж, техник, хэрэгсэл	79,900.00
Урсгал засвар	2,600.00
Бараа үйлчилгээний бусад зардал	3,855.00
Бараа үйлчилгээний бусад зардал	3,855.00
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>190.00</b>
<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>(190.00)</b>
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(190.00)

#### **Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 2.7 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 3 төлбөрийн акт, 1 зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

*Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2.7 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 5.3 сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.*

#### **5.1 Төлбөрийн акт**

Тус байгууллага нь сахилгын шийтгэл ногдуулсан 1 ажилтанд 1.5 сая төгрөгийн урамшуулал олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-д *“Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, 16 дугаар зүйлийн 5.5-д *“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д *“Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”*, 18 дугаар зүйлийн 18.1-д *“Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”*, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын *“Төрийн албан хаагчид шагнал, урамшуулал олгох”* журмын 2 дугаар зүйлийн 2.7-д *“Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй.”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:  
*Төлбөрийн акт тогтоосон.*

Рашаант сумын ЗДТГ нь 2025 онд сумын Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарт 0.7 сая төгрөгөөр нормын хувцас худалдан авч зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-д *“Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, 16 дугаар зүйлийн 5.5-д *“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д *“Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”*, 13 дугаар зүйлийн 13.7-д *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”*, 18 дугаар зүйлийн 18.1-д *“Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д *“Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно.”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:  
*Төлбөрийн акт тогтоосон.*

Тус байгууллага нь сумын ЗДТГ-ын нөөц хөрөнгөөс тэмцээн уралдааны зардалд 0.5 сая төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-д *“Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, 16 дугаар зүйлийн 5.5-д *“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д *“Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”*, 18 дугаар зүйлийн 18.1-д *“Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д *“байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах.”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.



